

ЕРТӨНЦ ДЭЭРХ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ ТУНХАГЛАЛ

ОРШИЛ

Ертөнц бол хувьсан өөрчлөгдөж байдаг амь амьдралын оршихуй бөгөөд амь амьдралтай хэн боловч энэ оршихуйн чухал хэсэг мөн. Иймээс бид бусдаас онцгой хүмүүн заяанд төрснийхөө хувьд бүгдээрээ “амьдрал” хэмээх асар том нийгэмлэгийн гишүүд тул тив дэлхийнхээ ирээдүйн төлөө нэгдмэл үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээх ёстой гэдгийг ухамсарлаж байна.

Бидний хэн ч ертөнцийн хувьсал өөрчлөлтөд хувь нэмэр оруулах үүрэгтэй. Мөн хүн бүр дэлхийд энхтайван тогтоох үүрэг, хариуцлагатай амьдрах шаардлагатай байна. Өнөөг хүртэл ертөнц дээр зөвхөн хэсэг бүлэг хүмүүс л амьдралын сайн сайхныг бүрэн гүйцэд амталж байна. Бид хязгаарлагдмал нөөц бололцоо, газар нутгийн төлөө дэлхий нийтийг хамарсан өрсөлдөөн тэмцэлдээнтэй нүүр тулан учирч байсан. Энэ бүгд нь эцсийн дүнд бүх нийтийг хамарсан байгаль орчинд хор уршиг тарьсан билээ.

Шинэ мянганд орж буй бидний хувьд дэлхий дээр энхтайван тогтоох явдал нь хүн төрөлхтөнг бүрдүүлэгч хэн боловч хүний ухамсар хэрхэн сэргэснээс давын өмнө илүү хамаарах нь тодорхой. Хүн бүр энхтайван, зохицол нийцэлтэй нийгэм байгуулах үүрэг хариуцлагыг зүрх сэтгэлдээ тээж явахыг өнөөгийн нөхцөл байдал шаардаж байна. Бид бүгдээрээ энэ нийтлэг үйл хэргийг гүйцэлдүүлэх ёстой. Хүн төрөлхтөнд хамаарах хэн боловч энэ нийтлэг үйл хэргийн төлөө сэтгэл зовниж, энэ зорилгын дор нэгдэж чадвал дэлхий дээр энхтайван тогтоно.

Өнөөг хүртэл хүн төрөлхтөн “эрх мэдэл, эд баялаг, алдар хүнд, мэдлэг мэргэжил, технологи, боловсрол”-ын хүрээнд хувь хүмүүс, үндэстэн, байгууллага гэж хуваагдан өмчтэй, өмчгүйгээрээ ялгарсан хэвээр байна. Түүнчлэн өглөг өгөгч, авагч, туслагч туслуулагчийн хооронд ялгаа байсаар л байна.

Иймд бид, энэ бүгд зааг ялгааг тогтоосон хил хязгаарыг гатлан давах тухай цоо шинэ цогц ойлголтыг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй гэдгийг тунхаглан зарлаж байна. Энэ нь энхтунх дэлхийг бий болгох үндэс болох юм.

ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Шинэ эринд хүн төрөлхтөн, хүн бүр, үндэстэн бүр, өрөөл бусад болон ертөнц дээрх бүхий л амь амьдралтай зохицож амьдрахдаа өөрийнхээ хувийн онцлог чанараа чөлөөтэй илэрхийлэх боломж бүхий дэлхийг бий болгох явдлыг зорилгоо болгоно. Үүний тулд дараахь зарчмуудыг удирдлага болгож байна. Үүнд:

1. Амьдралыг хүндэтгэх

Бид амьдралын бүхий л хэлбэрийг хүндэтгэсэн хайр энэрэл, зохицол дээр үндэслэн ертөнцийг байгуулна .

2. Бүхий л ялгааг хүндэтгэх.

Бид, хүний арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, соёл, уламжлал, зан заншлын бүхий л ялгааг хүндэтгэдэг ертөнцийг бий болгоно. Ийм дэлхий нь хүнийг нийгмийн байдал, бие бялдар, үзэл бодлоор нь ялгаварлах, сэргэлдүүлэхээс ангид байлгах бөгөөд олон үзэл бодол хосолсон, сэтгэлд нийцсэн орчин байх ёстой.

3. Байгал дээрх бүх зүйлд талархаж, тэдэнтэй зэрэгцэн орших

Бид, хүн бүр бүхий л амьтан, ургамал болон бусад амьд организмыг талархан дэмжиж байгаагаа харуулах замаар байгалиа шүтэж, байгальтайгаа зохицож амьдарч чадвал өөрсөддөө амьдрах боломж гаргана гэдгээ ухамсарласан дэлхийг бий болгоно.

4. Оюун санаа ба эд баялгын зохицол

Бид эд баялаг, оюун санааны зохицолын тэнцвэр бүхий иргэншил дээр үндэслэсэн дэлхийг бий болгоно. Бид хүн төрөлхтөн цэцэглэн хөгжихөд нөлөөлдөг эрүүл оюун санаа нь материаллаг эд зүйл дээр үндэслэдэг гэдэг ойлголтыг эвдэх ёстой. Бид элбэг дэлбэг материаллаг эд зүйлээс гадна оюун санаа үнэ цэнэтэй байх ертөнцийг бий болгоно.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид дор дурьдсан зүйлийг удирдлага болгон амьдралд нэвтрүүлнэ:

Хувь хүнийхээ хувьд:

Бид, улс үндэстэн, ястан, шашин дахь хэн нэгний эрх мэдэл, үүрэг хариуцлагын тулах цэг нь юуны өмнө хувь хүн байх эрин зуунд шилжих ёстой. Бид, "Хувь хүний эрин зуун"-ыг амин хувиа хичээх сэтгэлээр бус, харин хүн, хүн төрөлхтөний бие даасан гишүүнийхээ хувьд хийж гүйцэтгэсэн үйл хэргийнхээ төлөө хариуцлага хүлээхэд бэлэн байх эрин зуунаар төсөөлж байна.

Бидний хэн нь ч дэлхий нийтэд хайр энэрэл, зохицол нийцэл, талархал авчрах манай аугаа их үйл хэргийг сэтгэл зүрхэндээ тээж явах болно.

Тодорхой мэргэжлийн салбаруудад:

Бид, техникийн өндөр мэдлэг, ур чадварыг боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, шашин, гүн ухаан, улс төр, эдийн засгийн салбаруудад нэвтрүүлж, хослуулсан хамтын ажилгааны тогтолцоог бий болгоно.

Залуу үеийн хувьд:

Хорьдугаар зуунд эцэг эх, багш нар, нийгэм гээд бүгд л хүүхдэд мэдлэг боловсрол олгодог байсан бөгөөд хүүхдүүд зөвхөн сурдаг байдалд байсан. Харин 21 дүгээр зуунд томчууд нь хүүхдийн цагаан цайлган зан, эгэл жирийн байдал, цог золбоо, хурц ухаан, зөн совин болон тэдний бие биенээ хөгжөөж урамшуулдаг сайхан чанараас суралцах болно. Хүн төрлөхтөний гэрэлт ирээдүйн үндэс энхтайваныг тогтоох их үйлсэд залуу үе гол үүрэг гүйцэтгэх болно.

Даян дэлхий энх амгалан байг!